



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/18

Чойр

Батлан хамгаалах хууль,
тогтоомжийн хэрэгжилтийн байдалд
шалгалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.4, 34 дүгээр зүйлийн 34.3, 34.6.4 дэх заалт, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2004 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 66 дугаар тогтоолоор батлагдсан "Аймаг, нийслэл, дүүргийн Цэргийн штабын дүрэм"-ийн 1.2, 3.1, 9.3, 9.4, 10, 15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Цэргийн үүрэгтний үзлэг, Батлан хамгаалах хууль тогтоомжийн хяналт шалгалтад хамрагдах байгууллага, аж ахуйн нэгжийн жагсаалтыг нэгдүгээр, хяналт шалгалт явуулах ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цэргийн үүрэгтний үзлэг шалган туслах ажлыг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга

Б.Баянмөнх (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа)

Гишүүд:

Н.Оюунбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, ахмад)

Б.Нэргүйцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

3. Удирдамжийн дагуу хяналт шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа 18-50 насны эрэгтэйчүүдийн цэргийн үүргийн биелэлтийг шалгаж, үзлэгт бүрэн хамруулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, Батлан хамгаалах хууль, тогтоомжийн талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэн танилцуулахыг Ажлын хэсэг (дэд хурандаа Б.Баянмөнх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.СОДНОМ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2021 оны 04 дүгээр сарын 04-ны
өдрийн 118 дугаар тушаалын хавсралт



Цэргийн үүрэгтний үзлэг, Батлан хамгаалах хууль
тогтоомжийн хяналт шалгалтад хамрагдах
байгууллага, аж ахуйн нэгжийн жагсаалт

д/д	Байгууллага, Аж ахуйн нэгж	Шалгалтад хамрагдах хугацаа	Тайлбар
1	Нэгдсэн эмнэлэг	II улиралд	
2	БЗӨБЦТС ТӨХК-ний Говьсүмбэр дахь салбар	II улиралд	
3	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	II улиралд	
4	БОАЖГ	II улиралд	
5	Баянтал сумын ИТХ, ЗДТГ	II улиралд	
6	БТСГ	II улиралд	
7	Аймгийн Боржигин чуулга	II улиралд	
8	Мэргэжлийн хяналтын газар	II улиралд	
9	Сүмбэр сумын ИТХ, ЗДТГ	II улиралд	
10	Аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар	II улиралд	
11	Эрүүл мэндийн газар	II улиралд	
12	Төрийн аудитын газар	II улиралд	
13	ПТКоллеж	II улиралд	
14	Нийгмийн даатгалын хэлтэс	III улиралд	
15	Талын-Илч ОНӨААТҮГ	III улиралд	
16	Төрийн банкны Говьсүмбэр салбар	III улиралд	
17	Төмөр зам	III улиралд	
18	УС-ДУ ОНӨААҮГ	III улиралд	

19	Ус цаг уур, орчны шинжилгээний төв	III улиралд	
20	Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар	III улиралд	
21	Хаан банк	III улиралд	
22	Шивээ-Овоо ХК	III улиралд	
23	Шивээговь сумын ИТХ, ЗДТГ	III улиралд	
24	Тохижилт Сүмбэр ОНӨҮГ	III улиралд	